



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 12 сарын 07 өдөр

Дугаар Б/96

Бор-өндөр сум

Үйлчлэгч Г.Мөнгөнцэцэгийг
үүрэгт ажлаас нь чөлөөлж мэс заслын үйлчлэгчээр
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 50 дугаар зүйлийн 50.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын 2023 оны “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” 240 тоот тогтоолын 6 дугаар хавсралт, “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 тоот тогтоолын 10 дугаар хавсралт, 2022 оны “Журамд өөрчлөлт оруулах тухай” 491 тоот тогтоол, 2018 оны “Журам батлах тухай” 382 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт, Эрүүл мэндийн сайдын 2018 оны “Эрүүл мэндийн салбарын төрийн албан хаагчдын хоол унааны хөнгөлөлт, нэмэгдэл, урамшлын хэмжээг тогтоох тухай” А/548 тоот тушаал, 2020 оны “Хамтын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах тухай” А/69 дугаар тушаал, тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хэвтэн эмчлүүлэх тасгийн үйлчлэгч Гришагийн Мөнгөнцэцэг нь өөрийн хүсэлтээр мэс заслын сувилагчаар ажиллах хүсэлт гаргасан тул 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2. Г.Мөнгөнцэцэгийн ажлыг хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Комиссын дарга	Д.Борбил	Өмч хамгаалах комиссын гишүүн
Гишүүд	Б.Уранчимэг	Хэвтэн эмчлүүлэх тасгийн үйлчлэгч
С.Рагчаасүх	Архив, бичиг хэргийн ажилтны хавсран гүйцэтгэгч	

3. Г.Мөнгөнцэцэгийг 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрөөс Мэс заслын үйлчлэгчээр томилон ТҮ1 шатлалаар тогтоон үндсэн цалинг 750.000 (долоон зуун тавин мянга), хоолны мөнгө өдрийн 3000 (гурван мянга), төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл 7% 52.500 (тавин хоёр мянга таван зуу), хөдөлмөрийн хэвийн бус нөхцлийн нэмэгдэл

цалингийн 10% 75.000 (далан таван мянга) төгрөгөөр тус тус тооцож олгохыг Нягтлан бодогч (Т.Эрдэнэболор)-д зөвшөөрсүгэй.

4. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ёс зүйн хэм хэмжээг мөрдөн ажиллахыг Г.Мөнгөнцэцэгт үүрэг болгосугай.

ДАРГА



А.БАТБААТАР